



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/383

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын арслан Ш.Ванчинхүүгийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан үндэсний их баяр наадмын “Их сорилго” барилдааныг зохион байгуулах арга хэмжээний зардалд 10 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээний зардал 10000000 төгрөг /Арван сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 9/03 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 5.7 дахь заалт “Улсын арслан Ш.Ванчинхүүгийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан үндэсний баяр наадмын их сорилго барилдааны арга хэмжээний дэмжлэг” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 19-ний өдрийн
А/383 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН АРСЛАН Ш.ВАНЧИНХҮҮГИЙН МЭНДЭЛСНИЙ 110
ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН "ИХ СОРИЛГО"
БАРИЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

дд	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэг брийн үнэ	Нийт дүн	Тайлбар
1	Ш.Ванчинхүү арслангийн хөшөө барихад дэмжлэг		5000000	5000000	
2	Аймгийн харьяат Улсын цолтой ахмад бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэх		-	2000000	
3	Ховд бөхийн дэвжээний бөхчүүдэд Улсын баяр наадмын бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх		-	2000000	
4	Аймгийн баяр наадамд барилдах "Тунгалаг Буянт галын бөхчүүдэд бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх		-	1000000	
	Нийт дүн			10 000 000	

-oOo-